



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 01

Алтай

**Улсын аварга малчинд  
тодорхойлох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 202 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Улсын аварга малчин” шалгаруулах журам, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Улсын аварга малчин” шалгаруулах журмын шалгуур үзүүлэлтийг хангаж 1 дүгээрт эрэмбэлэгдсэн Жаргалан сумын малчин С.Эрдэнэбат, 2 дугаарт эрэмбэлэгдсэн Тонхил сумын малчин И.Баянмөнх, 3 дугаарт эрэмбэлэгдсэн Дарив сумын малчин Я.Амартүвшин, 4 дүгээрт эрэмбэлэгдсэн Дэлгэр сумын малчин Н.Гонгоржав, 5 дугаарт эрэмбэлэгдсэн Цээл сумын малчин А.Төвжав нарыг “Улсын аварга малчин” цолоор шагнуулахаар уламжилсугай.

2. С.Эрдэнэбат, И.Баянмөнх, Я.Амартүвшин, Н.Гонгоржав, А.Төвжав нарын ажлын үзүүлэлт, тодорхойлолт материалыг хугацаанд нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэхийг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ